



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/А94

Булган сум

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 419 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсөв, аймгийн байгаль хамгаалах сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024, 2025 онд ашиглалтад орсон барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, худгийн барилга, гүний худгийн дагалдах хэрэгсэл данс бүртгэлд авах 6,926,569,100 (зургаан тэрбум есөн зуун хорин зургаан сая таван зуун жаран есөн мянга нэг зуу) төгрөгийн хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор хүлээн авч, данс бүртгэлд бүртгэсэн тайланг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Орон нутгийн газарт ирүүлэх, 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж тайлагнахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч, Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж 2025 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай тооцоо нийлж баталгаажуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325011199

Аймгийн Засаг даргын 2025 оны  
 12 дугаар сарын 18-ны өдрийн  
 А.17.94 дугаар захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛД АВАХ  
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үнийн дүн (төгрөгөөр)	Ашиглалтад хүлээн авах сум байгууллага	Гүйцэтгэгч компани	Хөрөнгийн эх үүсвэр
1	2	3	4	5	6
1	Суурьшлын бүсийн цахилгаан хангамж (Хишиг-Өндөр сум)	166,846,200	Хишиг-Өндөр сумын ЗДТГ	Бошголсон ХХК	Орон нутгийн төсөв
2	Сумын төвийн авто замын үргэлжлэл (Бугат сум)	479,219,900	Бугат сумын ЗДТГ	Энх алтаргана ХХК	Орон нутгийн төсөв
3	Шинэ суурьшлын бүсэд гадна дулаан цэвэр усны шугам сүлжээ татах (Баян-Агт сум)	235,563,500	Баян-Агт сумын ЗДТГ	Ээлт өлгий ХХК	Орон нутгийн төсөв
4	Халуун усны барилгын гадна цахилгаан (Баян-агт сум)	24,675,000	Баян-Агт сумын ЗДТГ	Тэгш ургах ХХК	Орон нутгийн төсөв
5	ЕБСургуулийн сантехникийн засвар (Дашинчилэн сум)	29,683,000	Дашинчилэн сумын Ерөнхий боловсролын сургууль	Жи эм жи юу ХХК	Орон нутгийн төсөв
6	Булган аймгийн Булган сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн засварын төсөл	833,400,000	Булган хангай МСҮТ	Хурмастын хүлэг ХХК	Орон нутгийн төсөв
7	Суурьшлын бүсийн цахилгаан хангамж (Хишиг-Өндөр сум)	145,353,400	Хишиг-Өндөр сумын ЗДТГ	Өвөлжөөн булаг ХХК	Орон нутгийн төсөв
8	Сумын төвийн зам засвар (Булган сум)	188,472,300	Тохижилт үйлчилгээний анги	Энх алтаргана ХХК	Авто замын сан
9	Шар тал хэсгийн шинэ суурьшлын бүсийн 10/0,4 кВТ-ын ЦДАШ, 250 кВТ-ын дэд станцын цахилгааны ажил (Хангал сум, Хялганат)	116,377,600	Хялганат тосгон Захирагчийн ажлын алба	Сайжрах шилтгээн ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
10	Сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (Тэшиг сум)	379,128,500	Тэшиг сумын Эрүүл мэндийн төв	Бүлээн оргил ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
11	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны засвар (Баяннуур сум)	298,220,500	Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль	Ланд-арч ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
12	Гэрэлтүүлгийн өргөтгөл, хүчин чадлыг нэмэгдүүлэх (Булган сум Зүүнтүрүү 4-р баг)	113,629.200	Тохижилт үйлчилгээний анги	Сайжрах шилтгээн ХХК	Орон нутгийн хөгжлийн сан

1	2	3	4	5	6
13	Шинэ суурьшлын бүсийн 0.4кВ-ын ЦДАШ-ын өргөтгөл (Баян-Агт сум)	57,000,000	Баян-Агт сумын ЗДТГ	Сервис По сименс ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
14	Халуун усны барилга шинээр барих (Гурванбулаг сум)	224,982,700	Гурванбулаг сумын ЗДТГ	Баян-Өндөр булаг ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
15	Усны эх үүсвэрийг хамгаалах, хуримтлуулах, зүй зохистой ашиглах зорилгоор усан хангамжийн төвлөрсөн шугам сүлжээний 1-р шатны ажил (Могод сум)	991,049,800	Могод сумын ЗДТГ	Баатар шүтээн уул ХХК	Байгаль хамгаалах сан
16	Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор Булган сумын 6-р багийн 15, 16, 17-р гудамжны дулааны шугам өргөтгөл	751,420,100	"Булган МЭЭЖ" ОНӨХХК	Хулдын бүлээн ХХК	Байгаль хамгаалах сан
17	Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор "Дан" байрны дулаан, цэвэр усны шугамын өргөтгөлийн 2-р шатны ажил (Хангал сум, Хялганат тосгон)	325,166,800	Хялганат тосгон Захирагчийн ажлын алба	Сувдан элс ХХК	Байгаль хамгаалах сан
18	Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор 3 дугаар Ус дулаан дамжуулах төвөөс 7 дугаар цэцэрлэг хүртэлх ДХ143-ДХ129-р худаг чиглэлийн гадна дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамын өргөтгөл, шинэчлэл (Булган сум)	712,652,800	"Булган МЭЭЖ" ОНӨХХК	Гуа-Орд ХХК	Байгаль хамгаалах сан
19	Цэвэр ус хангамжийн нэгдсэн систем шинээр байгуулах 2 дугаар шатны ажил (Булган сум, 4-р баг)	493,596,500	"Булган МЭЭЖ" ОНӨХХК	Сувдан элс ХХК	Байгаль хамгаалах сан
20	Өрхийн эмнэлгийн дулаан, цэвэр бохир усны системд холбох (Булган сум, Эмийн цэцэглэн ӨЭМТ)	293,960,500	"Булган МЭЭЖ" ОНӨХХК	Голдкомпас ХХК	Байгаль хамгаалах сан
21	Хог хаягдлыг зайлуулах зориулалтаар экскаватор авах (Сайхан сум)	179,800,000	Сайхан сумын ЗДТГ	Би Би Кей Эйч ХХК	Байгаль хамгаалах сан
	<b>Нийт дүн</b>	<b>6,926,569,100</b>			